# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2023/10/НА-СТА-ТЗШ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мөрөн сум<br>2023 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Б.Даваанням<br>Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn<br><br>Аудитор: Г.Ичинхорлоо<br>Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 4

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 11

**4.1 Ерөнхий зүйл** ..... 14

**4.2 Материаллаг байдал** ..... 14

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 14

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илэрсэнгүй. ..... 14

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 14

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 14

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 15

**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 15

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 15

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.17 № 01/78
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШҮҮХ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
С.МӨНХБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь Монгол улсын шүүхийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байсан бол тайлант онд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл өргөн барьж 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн сайдын 2023 оны "Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/10 дугаар тушаалаар Шүүхийн шинжилгээний алба нь Шүүх шинжилгээний хэлтэс болон өргөжсөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Хөвсгөл аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс нь тайлант онд хэрэгжүүлэхээр нийт 4 зорилт 46 арга хэмжээг төлөвлөж 88.7 хувь хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу

илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /А.ЭРДЭНЭБААТАР/

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,494,387.60** | **17,919,981.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **5,494,387.60** | **17,919,981.00** |
| **351** | **Түүхий эд материал** | **1,252,930.00** | **1,962,380.00** |
| 35130 | Эм боох материал | 1,252,930.00 | 1,962,380.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **4,241,457.60** | **15,957,601.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 583,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,941,520.00 | 14,705,501.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 668,600.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 299,937.60 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **154,099,151.00** | **150,628,912.68** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **154,099,151.00** | **150,628,912.68** |
| **392** | **Биет хөрөнгө** | **42,099,151.00** | **38,628,912.68** |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 44,700,000.00 | 44,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18,616,666.86 | -26,066,666.94 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 35,130,760.00 | 47,371,140.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -23,480,372.10 | -30,397,553.62 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,338,630.28 | 10,338,630.28 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -5,973,200.32 | -7,316,637.04 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **112,000,000.00** | **112,000,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 112,000,000.00 | 112,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **159,593,538.60** | **168,548,893.68** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **159,593,538.60** | **168,548,893.68** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **159,593,538.60** | **168,548,893.68** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 115,485,200.00 | 115,485,200.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 115,485,200.00 | 115,485,200.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **44,108,338.60** | **53,063,693.68** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 44,108,338.60 | 44,108,338.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 8,955,355.08 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **159,593,538.60** | **168,548,893.68** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **221,765,500.00** | **244,913,559.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,920,500.00** | **14,746,058.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,920,500.00** | **14,746,058.50** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,920,500.00 | 14,746,058.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,920,500.00 | 3,712,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 11,034,058.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **217,845,000.00** | **230,167,501.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **212,372,000.00** | **219,560,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 212,372,000.00 | 219,560,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **5,473,000.00** | **10,607,401.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 6,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,473,000.00 | 4,107,401.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **233,481,775.04** | **235,958,204.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **233,481,775.04** | **235,958,204.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **232,561,275.04** | **234,901,378.31** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **186,668,500.00** | **183,001,225.16** |
| 210101 | Үндсэн цалин | 186,668,500.00 | 118,681,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 50,726,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 10,110,225.16 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 3,483,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **4,363,500.00** | **3,828,956.73** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 850,613.00 | 140,448.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 94,472.00 | 16,523.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 75,565.00 | 13,218.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,895.00 | 3,304.61 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,323,955.00 | 3,655,462.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **2,565,000.00** | **2,058,500.00** |
| 210304 | Байрны түрээс | 2,565,000.00 | 2,058,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,224,735.40** | **13,808,513.60** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,865,780.00 | 2,818,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,908,555.40 | 7,895,737.60 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 | 1,858,356.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,550,400.00 | 1,236,020.00 |
| **2105** | **Норматив зардал** | **2,791,400.00** | **9,036,650.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,791,400.00 | 8,436,350.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 600,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,999,000.00** | **1,133,900.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 450,000.00 | 165,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,549,000.00 | 968,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,154,000.00** | **4,040,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,154,000.00 | 4,040,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,691,600.00** | **2,489,336.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,221,600.00 | 1,080,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 97,200.00 | 126,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 78,436.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 252,800.00 | 204,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,103,539.64** | **15,504,296.82** |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 14,103,539.64 | 15,504,296.82 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **920,500.00** | **1,056,826.11** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **920,500.00** | **1,056,826.11** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 920,500.00 | 1,056,826.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-11,716,275.04** | **8,955,355.08** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-11,716,275.04** | **8,955,355.08** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **221,765,500.00** | **233,879,501.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,920,500.00** | **3,712,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,920,500.00** | **3,712,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **3,920,500.00** | **3,712,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,920,500.00 | 3,712,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **217,845,000.00** | **230,167,501.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **212,372,000.00** | **219,560,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 212,372,000.00 | 219,560,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **5,473,000.00** | **10,607,401.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 6,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,473,000.00 | 4,107,401.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **220,170,180.00** | **232,879,501.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **220,170,180.00** | **232,879,501.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **219,249,680.00** | **231,822,674.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **186,668,500.00** | **183,001,225.16** |
| 210101 | Үндсэн цалин | 119,334,292.00 | 118,681,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 57,388,632.72 | 50,726,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,945,575.28 | 10,110,225.16 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 3,483,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **4,363,500.00** | **3,828,956.73** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 140,448.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 16,523.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 13,218.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 3,304.61 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,363,500.00 | 3,655,462.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **2,565,000.00** | **2,058,500.00** |
| 210304 | Байрны түрээс | 2,565,000.00 | 2,058,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,474,280.00** | **13,995,856.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,864,480.00 | 3,401,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,900,000.00 | 7,595,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 | 1,858,356.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,809,800.00 | 1,139,800.00 |
| **2105** | **Норматив зардал** | **2,900,000.00** | **9,940,800.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,900,000.00 | 9,145,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 795,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,999,000.00** | **8,968,001.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 450,000.00 | 309,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,549,000.00 | 8,658,801.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,154,000.00** | **4,040,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,154,000.00 | 4,040,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,125,400.00** | **3,989,336.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,655,400.00 | 2,580,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 97,200.00 | 126,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 78,436.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 252,800.00 | 204,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **00.00** | **2,000,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 2,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **920,500.00** | **1,056,826.11** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **920,500.00** | **1,056,826.11** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 920,500.00 | 1,056,826.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,595,320.00** | **1,000,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,595,320.00** | **1,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,595,320.00** | **1,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **1,595,320.00** | **1,000,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,595,320.00 | 1,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-1,595,320.00** | **-1,000,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **115,485,200.00** | **00.00** | **55,824,613.64** | **171,309,813.64** |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **115,485,200.00** | **00.00** | **55,824,613.64** | **171,309,813.64** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -11,015,616.04 | -11,015,616.04 |
| **C08** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **115,485,200.00** | **00.00** | **44,108,338.60** | **159,593,538.60** |
| **D01** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **115,485,200.00** | **00.00** | **44,108,338.60** | **159,593,538.60** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **115,485,200.00** | **00.00** | **44,108,338.60** | **159,593,538.60** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 8,955,355.08 | 8,955,355.08 |
| **D09** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **115,485,200.00** | **00.00** | **53,063,693.68** | **168,548,893.68** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 222,560,100.0 | 222,215,273.9 | 344,826.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 222,560,100.0 | 222,215,273.9 | 344,826.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 222,560,100.0 | 222,215,273.9 | 344,826.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 183,227,000.0 | 183,001,225.2 | 225,774.8 |
| 210101 | Үндсэн цалин | 118,681,800.0 | 118,681,800.0 | 00.0 |
| 210102 | Нэмэгдэл | 50,726,200.0 | 50,726,200.0 | 00.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,336,000.0 | 10,110,225.2 | 225,774.8 |
| 210104 | Урамшуулал | 3,483,000.0 | 3,483,000.0 | 00.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,914,500.0 | 3,828,956.7 | 85,543.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 143,000.0 | 140,448.3 | 2,551.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,000.0 | 16,523.0 | 477.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,500.0 | 13,218.4 | 281.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,500.0 | 3,304.6 | 1,195.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,736,500.0 | 3,655,462.3 | 81,037.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,058,500.0 | 2,058,500.0 | 00.0 |
| 210304 | Байрны түрээс | 2,058,500.0 | 2,058,500.0 | 00.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,995,900.0 | 13,995,856.0 | 44.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,401,900.0 | 3,401,900.0 | 00.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,595,800.0 | 7,595,800.0 | 00.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,858,400.0 | 1,858,356.0 | 44.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,139,800.0 | 1,139,800.0 | 00.0 |
| **2105** | **Норматив зардал** | 9,940,800.0 | 9,940,800.0 | 00.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 9,145,800.0 | 9,145,800.0 | 00.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 795,000.0 | 795,000.0 | 00.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,860,600.0 | 2,860,600.0 | 00.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,000,000.0 | 1,000,000.0 | 00.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 309,200.0 | 309,200.0 | 00.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 1,551,400.0 | 1,551,400.0 | 00.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,040,000.0 | 4,040,000.0 | 00.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,040,000.0 | 4,040,000.0 | 00.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,522,800.0 | 2,489,336.0 | 33,464.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,080,000.0 | 1,080,000.0 | 00.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 126,100.0 | 126,100.0 | 00.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,500.0 | 78,436.0 | 2,064.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16,100.0 | 00.0 | 16,100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.0 | 1,000,000.0 | 00.0 |
| 210807 | Газрын төлбөр | 220,100.0 | 204,800.0 | 15,300.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 222,560,100.0 | 222,215,273.9 | 344,826.1 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 219,560,100.0 | 219,215,273.9 | 344,826.1 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 219,560,100.0 | 219,215,273.9 | 344,826.1 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 3,000,000.0 | 3,000,000.0 | 00.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,000,000.0 | 3,000,000.0 | 00.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 11.00 | 11.00 | 00.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 10.00 | 00.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,607,401.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,607,401.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **10,607,401.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,107,401.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,107,401.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,500,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,500,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 10,607,401.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,607,401.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,500,000.00 |

| | | |
|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,107,401.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шинжилгээний байгууллага нь эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх, түүнд үзлэг, үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах тусгай чиг үүрэг бүхий төрийн тусгай алба юм.

Эрхэм зорилго: Шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн боловсронгуй орчин, оновчтой зохион байгуулалт, баталгаатай арга зүй, техник-технологийн дэвшлийг бүрэн ашиглах нөхцлийг бий болгон, хүний нөөцийн чадварлаг баг бүрдүүлснээр аливаа хэргийг шинжлэх ухааны нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:*** Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь үйл ажиллагаандаа дараах хууль эрх зүйн орчныг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Шүүхийн шинжилгээний тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэх мэт бусад хууль тогтоомжууд.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:*** Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнд Хяналт,шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс ажилладаг бөгөөд тайлант онд Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. ***Тухайлбал:*** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн захирлын 2006 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 76 дугаар тушаалаар батлсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,955.3 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 5,494.4 | 17,919.9 | 12,425.5 |
| Үндсэн хөрөнгө | 154,099.2 | 150,628.9 | -3,470.3 |
| **Нийт хөрөнгө** | **159,593.6** | **168,548.9** | **8,955.3** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **159,593.6** | **168,548.9** | **8,955.3** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **159,593.6** | **168,548.9** | **8,955.3** |

Дээрх хүснэгтээс харахад бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 12,425.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь шинжээчид газар дээрх задлан шинжилгээ хийх, дээж авах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэхдээ машинаа халхлах асар майхан, хулдаас зэрэг хангамжийн материал худалдан авсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 280,594.0 мянга, нийт зарлагыг 280,594.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 51,221.0 мянган төгрөгөөр бууруулж, 229,373.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь албаны байрыг хашаатай болгох зорилгоор урсгал засварын зардлыг өндөр тооцсонтой холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 6,812.9 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 219,560.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 222,215.3 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70707-Шүүхийн шинжилгээ | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 221,480.1 | 221,135.3 | 344.8 | 99.8% |
| 2 | | 82311-Шүүхийн шинжилгээний тусгай ажиллагааны зардал | 1,080.0 | 1,080.0 | 0 | 100% |
| Нийт дүн | | | 222,560.1 | 222,215.3 | 344.8 | 99.8% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

1. Тайлант онд ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс хуваарилсан 6,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос лабораторийн бодис, химийн нэгдэл, эд эсийн жинг нарийвчлалтай хэмжихэд шаардлагатай электрон жин 1,500.0 мянган төгрөг, байгууллагын албаны байр барих зориулалттай газарт 5,000.0 мянган төгрөгөөр 200 метр хашлага, хайс барьсан байна.

2. Үндсэн үйл ажиллагааны орлогоос давсан 4,107.4 мянган төгрөгөөс 2,107.4 мянган төгрөгөөр албаны байранд хангамжийн материал авсан, 2,000.0 мянган төгрөгөөр хөдөө хээр шинжилгээнд ашиглах зориулалт бүхий асар тус тус худалдан авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Даваанням, аудитор Г.Ичинхорлоо нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр , дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 12т/21 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 233,481.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4,669.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илэрсэнгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

1. Нийт 20 мэдээлэл байршуулахаас 18 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.
2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 231,750.0 мянган төгрөгийн 17 гүйлгээ, зарлагын 5,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээний мэдээллийг 100 хувь хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд мэдээлсэн, 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илэрсэн 3,098.0 мянган төгрөгийн 1 зөрчилд батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж Засгийн газрын 2021 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах тухай 1 зөвлөмж өгсөн байна. Тайлант онд 1,500.0 мянган төгрөгийн эдийн засгийн ангилал зөрчсөн гүйлгээ гарсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 3,098.0 | 1 | 1,598.0 | 51.6% |
| **Нийт дүн** | 1 | 3,098.0 | 1 | 1,598.0 | 51.6% |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар алдаа, зөрчилтэй асуудал илэрсэнгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ӨРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР Б.ДАВААНЯМ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: 2023.02.1